



РЕСУРСПАРТНЕРС ГРУПП ХХК

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021578 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “ХАВТГАЙ-III ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРД”-ЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



2025 он



РЕСУРСПАРТНЕРС ГРУПП ХХК

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021578 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “ХАВТГАЙ-III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР - MV-021578/

/АЖ АХУЙ НЭГЖ РЕГИСТРИЙН ДУГААР - 5556554/

Ресурспартнерс групп ХХК-ний Гүйцэтгэх захирал:



Д.Даяндэмэд

Тайлан боловсруулсан: Байгаль орчны мэргэжилтэн:

Д.Буянзул

2025 он

АГУУЛГА

ОРШИЛ.....	4
I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5
II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	7
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	10
V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.	12
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
5.1.1. Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажлын биелэлт	13
5.1.2. Газрын доорх усны сөрөг нөлөөллийг бууруулах ажлын биелэлт	13
5.1.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын биелэлт	15
5.1.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах ажлын биелэлт	16
5.1.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын биелэлт	17
5.2. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөний биелэлт	19
5.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	22
5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	24
5.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт.....	24
5.6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	24
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	25
5.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	30
5.8.1. Агаарын чанарын хэмжилт, шинжилгээний аргачлал.....	31
5.8.2. Агаарын хэмжилт, судалгааны үр дүн	33
5.8.3. Хөрсний хяналт шинжилгээ	34
5.8.4. Усан орчны хяналт шинжилгээ.....	38
5.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	40
5.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	40
5.11. 2025 онд орон нутагт хийгдсэн ажлууд	42

ТАЙЛАНГИЙН ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга.....	5
Хүснэгт 2. Уурхайн лицензийн талбайн солбицол.....	6
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 5. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	22
Хүснэгт 6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	25
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний ажлын төлөвлөгөө.....	30
Хүснэгт 9. Агаарын хяналт шинжилгээний цэгийн байршил.....	32
Хүснэгт 10. Агаарын чанарын шинжилгээний дүн.....	33
Хүснэгт 11. Хөрсний хяналт шинжилгээний дүн.....	34
Хүснэгт 12. Хөрсний мониторингийн цэгүүд дэх химийн шинжилгээний үзүүлэлтүүд.....	36
Хүснэгт 13. Хөрсний мониторинг цэгүүд дэх хүнд металлын агууламж (10-р сар).....	37
Хүснэгт 14. Усан орчны мониторингийн цэгийн ерөнхий мэдээлэл.....	39
Хүснэгт 15. Усны ерөнхий химийн шинжилгээний дүн.....	39
Хүснэгт 16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	40
Хүснэгт 17. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	40
Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байршил.....	6
Зураг 2. Асгаралтын багц.....	13
Зураг 3. Ажилчдыг сургалт мэдээллээр хангасан байдал.....	13
Зураг 4. Унд ахуйд ус ашигласны төлбөр.....	14
Зураг 5. Шимт хөрсний овоолгын байршил.....	15
Зураг 6. Шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлсэн байдал.....	16
Зураг 7. Уурхайн кемп орчимд хийгдсэн мод тарилтын ажил.....	16
Зураг 8. Уурхайн талбайн орчимд шувууны суулт байршуулсан байдал.....	18
Зураг 9. ЦДАШ-д шувуу үргээгч суурилуулсан байдал.....	18
Зураг 10. Сумын төвд мод тарилтын ажил.....	19
Зураг 11. Сумын төвд мод тарилтын ажил.....	20
Зураг 12. Шимт хөрсний овоолго (2025.07 сар).....	21
Зураг 13. Хогийн цэг дээр түрэлт хийж байгаа үеийн зураг.....	22
Зураг 14. Хогийн цэгт түрэлт хийсний дараах үеийн зураг.....	23
Зураг 15. Барилгын хог хаягдлыг хогийн цэг рүү тээвэрлэх үеийн зураг.....	23
Зураг 16. Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.....	24
Зураг 17. Кемпд гал унтраах бэлэн байдлыг хангасан байдал.....	25
Зураг 18. Ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав.....	26
Зураг 19. Ахуйн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээ.....	27
Зураг 20. Ахуйн хог хаягдлын төлбөр төлсөн баримт.....	27
Зураг 21. Аюултай хог хаягдлын цэгийг дахин тохижуулсан байдал.....	28
Зураг 22. Аюултай хог хаягдал шилжүүлэн өгөх гэрээ.....	29
Зураг 23. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийж буй байдал (10-р сар).....	32
Зураг 24. Агаарын хяналт шинжилгээ хийгдсэн цэгүүдийн байршил.....	33
Зураг 25. Хөрсний хэмжилт хийсэн цэгийн байршил.....	34
Зураг 26. Хөрсний хүнд металлын шинжилгээний хариу.....	37
Зураг 27. Усны мониторингийн цэгийн байршил.....	39
Зураг 28. Багийн хуралд танилцуулга хийх үеийн зураг.....	41

Зураг 29. Сумын төвийн зам засварын ажил	42
Зураг 30. Сумын төвийн зам засварын ажил	42
Зураг 31. Сумын төвийн зам засварын ажил	43
Зураг 32. Айлын өвөлжөөний бууц түрсэн ажил (айл 1).....	43
Зураг 33. Айлын өвөлжөөний бууц түрсэн ажил (айл 2).....	44
Зураг 34. Айлын өвөлжөөний бууц түрсэн ажил (айл 3).....	44

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ.....	47
Хавсралт 2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хуулбар.....	49
Хавсралт 3. Нөөцийн тушаал дүгнэлт	51
Хавсралт 4. Ордын нөөцийн тушаал, дүгнэлт.....	52
Хавсралт 5. ТЭЗҮ-ний тушаал, дүгнэлт.....	55
Хавсралт 6. Гол мөрний урсац бүрэлдэх эх, хамгаалалтын бүстэй давхцалгүй эсэх лавлагаа	56
Хавсралт 7. БОННУ-ний батлагдсан нүүр	57
Хавсралт 8. 2025 оны БОМТ батлагдсан нүүр	58
Хавсралт 9. 2025 оны барьцаа төлсөн баримтын хуулбар.....	59
Хавсралт 10. 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний батлагдан нүүр	60
Хавсралт 11. 2025 оны ус ашиглах дүгнэлт	61
Хавсралт 12. 2025 оны ус ашигласны төлбөр төлсөн баримт.....	64
Хавсралт 13. Унд ахуйн худагт тоолуур суурилуулсан акт.....	65
Хавсралт 14. 2025 оны ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булах, устгах гэрээ	66
Хавсралт 15. Ахуйн хог хаягдлын төлбөр төлсөн баримт	68
Хавсралт 16. Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ	69
Хавсралт 17. Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээт байгууллагын тусгай зөвшөөрөл	72
Хавсралт 18. Хөрсний хүнд металлын хариу	74
Хавсралт 19. Хөрсний химийн шинжилгээний дүн.....	75
Хавсралт 20. Хөрсний химийн шинжилгээний дүн.....	76
Хавсралт 21. Усны химийн шинжилгээний дүн	77
Хавсралт 22. Агаарын шинжилгээний дүн.....	78

ОРШИЛ

“Ресурспартнерс групп” ХХК-ийн барилгын чулууны ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг боловсруулахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ –нд тусгагдсан ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэхээр төлөвлөн зорьж ажиллаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Хавтгай 3 хайлуур жоншны уурхай нь 2025 онд 439.04 мян.м³ хөрс хуулалтын ажил хийж 148.4 мян.тн хүдэр олборлосон. Нийт уулын цулын хэмжээ 494.67мян.м³ байна.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 23.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж төлөвлөсөн ажлуудын гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Үйл ажиллагааны хүрээнд 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэхээс гадна орон нутаг сумын удирдлага, уурхайн нөлөөллийн бүсд байгаа айл өрхүүдээс тавьсан санал хүсэлтийн дагуу хийж гүйцэтгэх боломжтой ажлуудыг хийж гүйцэтгэж ажиллаа.

I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөвлөгөөний нэр: “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Ресурспартнерс групп” ХХК

Төслийн зорилго: “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ын хүдрийг олборлож, бутлан ангилан, сайн чанарын жоншыг зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга


№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Ресурспартнерс групп” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011328128	
3	Уурхайн нэр	Хавтгай-III	
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Хэнтий
5		Сум/Дүүрэг	Батноров
6	Ашигт малтмалын төрөл	Хүдэр	
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-021578	
8	Ашиглалт эхэлсэн огноо	2024	
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Чингэлтэй
11		Баг/Хороо	6-р хороо
12		Гудамж/Байр	Лааганы гудамж, 63А байр 01 тоот
13		Гар утас	99082810
14	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Д.Даяндэмэд
15		Гар утас	99082810
16		Электрон шуудан	dalaidayanaa@yahoo.com

Төслийн байршил: “Хавтгай -III” хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт байрладаг.

- Засаг захиргаа: Хэнтий аймаг, Батноров сум,
- Ордын нэр: "Хавтгай-III хайлуур жоншны орд"
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Хайлуур жонш
- Трапецийн номенклатур: М-4-139
- Талбайн нийт хэмжээ: 633.58 га

Хүснэгт 2. Уурхайн лицензийн талбайн солбицол

№	Газарзүйн солбицол			Өргөрөг		
	Уртраг			Өргөрөг		
1	111	27	1.88	48	5	51
2	111	27	1.88	48	6	51.85
3	111	28	31.87	48	6	51.85
4	111	28	31.87	48	7	51.82
5	111	27	1.88	48	7	51.82
6	111	27	1.88	48	7	1.81
7	111	25	41.87	48	7	1.81
8	111	25	41.87	48	6	36.04
9	111	26	7.18	48	6	35.76
10	111	26	7.18	48	5	51



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байршил

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл “Ресурспартнерс групп” ХХК-д 633.58 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-021578 дугаар бүхий гэрчилгээг 2020 оны 04 сарын 21- ний өдөр олгосон байна.

Уурхайн одоогийн байдал: “Ресурспартнер групп” ХХК нь Хавтгай-III хайлуур жоншны ордыг ашиглах ТЭЗҮ-ийг 2024 онд батлуулсан бөгөөд түүнээс хойш үйл ажиллагаа

явуулж байна.

Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц:

Ил уурхайн С зэрэглэлийн нөөцөд тулгуурлаж хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадласан В' үйлдвэрлэлийн нөөц нь 294.12 мян.тн хүдэр байна. Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр $6.92 \text{ м}^3/\text{м}^3$ буюу $2.55 \text{ м}^3/\text{тн}$ болж байна.

Төслийн хүчин чадал: 2024 оны төлөвлөгөөгөөр бүрэн хүчин чадлаараа буюу 193.0 мян.тонн хүчин чадалтай ажиллана. Орд нь эхний жилд 153 хоног хоёр дахь жилд 275 хоног ажиллана. Уурхайн үйл ажиллагаа нь хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Тэсэлгээний ажил: Тэсэлгээний ажилд дотоодод үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO” найрлагат тэсрэх бодис, мөн эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээг **10 хоногт нэг удаа** хийх ба тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу аюулгүй байдлыг дээд зэргээр хангасны үндсэн дээр ерөмдлөг-тэсэлгээний ажлыг мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээлэн гүйцэтгүүлнэ.

II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ландшафт: “Хавтгай-III хайлуур жоншны орд” нь ландшафтын мужлалаар Онон Улз голын сав газрын хөмбөн-цулдам нам уул, хотгор, суурьт тал бүхий хээр, хуурай хээрийн мужид багтана. Төслийн талбай орчим нь Монгол орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Хангай-Хэнтийн уулархаг их мужид харьяалагдана.

Уур амьсгал, агаарын чанар: Бүх талаараа Азийн өндөр уулсаар хүрээлэгдэж далай тэнгисээс ихээхэн алслагдсан, гипсометрийн өндөр байрлалд оршдог тул тэнгисийн чийглэг салхи нэвтрэх боломж тун бага байдаг онцлогтой. Цаг уурын энэ онцлог нь дүүргийг эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлын болон хоногийн халуун хүйтний хэлбэлзэл, өөрчлөлт ихтэй болгодог.

Өвөлдөө олон жилийн дундаж температур -20°C аас, -35°C хэм хүрч, дулаан нь 7-р сард 25 аас 30.9°C хүрнэ. Жилд унах хур тундасны дундаж хэмжээ 200-300 мм тунадас унана, Харьцангуй чийглэг уур амьсгалтай ба харьцангуй дундаж чийгшилт 35% байна. Салхины хурд өвөлдөө 1.8-2 м/сек хүртэл салхилдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-30 см орчим байдаг.

Усан орчин: Усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Ордын сумаар, Эхэнбүрд, Дундбүрд, Адагбүрд, Бургаст зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг.

Ордын сумын талбайд байгаа томоохон амууд, гуу жалга нь баруун, баруун хойш чиглэлтэй юм. Тэдгээрийн ихэнх нь эхэндээ бага зэргийн ундаргатай, булгуудтай, зарим нь түр зуурын урсгалтай жижиг горхиуд байдаг. Цас борооны усаар тэжээгддэг эдгээр горхиуд нь адаг руугаа шургаж тасардаг ба зарим нэг нь Бүхэг, Түргэний голд цутгадаг.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих талбай нь ухаа толгод бүхий нутаг хамрагдах бөгөөд талбайд тархсан хөрсний хувьд зонхилох хэв шинж нь уулын хар хүрэн хөрс, толгод болон нам уулсын хажуугаар чулуурхаг нимгэн хар шороон хөрс.

Ургамлан нөмрөг: Ойт хээрийн ба хээрийн бүсийн өвслөг, цэцэгт ургамал, газар зүйн бүх төрлийг хамаарах бөгөөд хадлан, бэлчээр газар тариалангийн талбайн хувьд дунд зэрэг төлөвтэй.

Амьтан: Тарвага, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, үнэг, хярс, шилүүс, мануул, дорго, туулай, чандага, өмхий хүрэн, зурам зэрэг ан гөрөөс элбэг байх ба буга, зэрлэг гахай нилээд байдаг байсан ч ховордсон. Хэрлэн мөрөнд соом, булуу цагаан, зэвгэ, цурхай загас байх ба зарим үед тул загас үзэгддэг.

Түүх соёлын дурсгалд газрууд: Үйл ажиллагаа явуулах төслийн талбайд түүх соёлын дурсгалт газрууд илрээгүй.

Хэнтий аймгийн Батноров сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Засаг захиргааны нэгжийн хувьд сум нь Эрдэнэчандмань, Эхэнбүрд, Баян, Баянбулаг, Идэрмэг, Дундбүрд, Бэрх гэсэн 7 багтай.

2023 оны жилийн эцсийн байдлаар Батноров суманд нийт 5689 хүн ам оршин сууж байна. Үүнээс 2913 нь эрэгтэй, 2776 нь эмэгтэй эзэлж байна. Өөрөөр хэлбэл Батноров сумын нийд иргэдийн 48.8% нь эмэгтэй, 51.2% нь эрэгтэй эзлэж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 1773 өрх бүртгэгдсэнээс 466 өрх буюу 61.3%-ийг 1 ам бүлтэй өрх эзлэж байна. Нийт өрхийн 845 нь малчин өрх байна. Мал сүрэг нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 328.7 мянган толгой мал үүнээс Тэмээ 0.2 мян.толгой, Адуу 32.7 мян.толгой, Үхэр 26.8 мян.толгой, Хонь 175.0 мян.толгой, Ямаа 93.9 мян.толгой мал тус тус тоолуулсан байна. (эх сурвалж: “Хэнтий аймгийн статистикийн эмхэтгэл 2023”, 2024 он)

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн төрийн 6 байгууллагатай. Хувийн хэвшлийн 72 аж ахуй нэгж, иргэн арьс шир боловсруулах, хүнсний дэлгүүр, талх гурилан боовны цех, цагаан идээ боловсруулах, гар урлал, үсчин гоо сайхан зэрэг жижиг дунд үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Томоохон уул уурхай Алтан гадас одонт Бэрхийн уурхай, Ямаатын уурхай, Хавтгайн уурхай, Чимэдийн уурхай, Баяжуулах үйлдвэр гэсэн байгалийн баялаг жонш үйлдвэрлэх, боловсруулах уурхай, үйлдвэрүүдтэй. Эдийн засгийн чадамжийн хувьд Бэрхээс тусдаа төсөвтэй явдаг бөгөөд сумын нийт төсөв нь жилийн 3.2 тэрбум.төгрөг, үүнээс сумын өөрийн татварын орлого 0.2 хувийг нь бүрдүүлэн төвлөрүүлдэг.

III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулах учраас газрын гадаргад өөрчлөлт орно. Хөрс хуулалт, гадаад болон дотоод овоолго, бутлах үйлдвэр, ажилтнуудын түр амьдрах байр зэрэг бүхий л уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлнө.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх, бутлуурт орж буй чулуулаг дахь тоос агаарт дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл байна.

Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Гадаргын болон газрын доорх усны нөөцөд нөлөөлөх нөлөөлөл бага байна.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдахаар байна.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй.

Эерэг нөлөөллийн хувьд амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны хотын тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөлөл: “Ресурспартнерс Групп” ХХК–ний ашиглалтын талбайн ойр орчимд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс, түүнтэй холбоотой эд өлгийн зүйлс илрээгүй байна.

Олборлолтын явцад түүх эд өлгийн олдвор олдсон тохиолдолд холбогдох Төрийн байгууллагад мэдэгдэн хамтран ажиллах шаардлагатай.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Улсад болон орон нутагт тодорхой хэмжээний татвар төлөх, ажлын байр нэмэгдүүлэх, нийслэл хотын барилга зам гүүрийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг түүхий эдээр хангах зэрэг эерэг нөлөөлөл байна.

Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл: Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-ний тайланг боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрд нийт 5 төрлийн ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эдгээр ажлын биелэлтийн хүрээнд хийгдсэн ажлуудын гүйцэтгэлийг холбогдох баримт материал, зургаар баталгаажуулан тайлагналаа.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх , бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Гүйцэтгэл
Агаарын чанар	Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох	Зам талбай, овоолго, тоос босох гадаргууг усалгаа хийж тоосжилт бууруулах арга хэмжээ авах	Уурхайн талбайд	Хийгдсэн
Гүний ус	Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх	Spill kit асаргалтын иж бүрдэл байрлуулах https://hsct.mn/	Төслийн хүрээнд	Хийгдсэн
Хөрсөн бүрхэвч	Техникийн нөхөн сэргээлтийг арга зүйн дагуу хийгээгүй тохиолдолд хөрсөн бүрхэвч доройтох, нөхөн сэргэх чадвараа алдах	Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалах, хамгаалах	Шимт хөрсний овоолго	Хийгдсэн
Ургамлан нөмрөг	Уурхайн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвч доройтох	Нутгийн унаган ургамлын үр түүх	Уурхайн талбайд	Хийгдсэн
Амьтны аймаг	ЦДАШ-ыг шувуу мөргөх, тогонд цохиулах	Шувууны суулт 2 ширхэг /үүр/ суурилуулах	Уурхайн талбай орчимд	Хийгдсэн

5.1.1. Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажлын биелэлт

Уурхайн уулын ажил цөөн тооны техникээр хийж гүйцэтгэсэн ба дулааны улиралд бороо хур элбэг хөрсөнд чийгшил хангалттай байсан тул нэмэлтээр тоосжилт дарах усалгаа хийх нөхцөл шаардлага үүсээгүй.

Агаарт агуулагдах нийт тоос, хүхэрлэг хий, азотын давхар ислийн хэмжилтийг уурхайн талбай дээр 2025 оны 10-р сард Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний лаборатори хээрийн хэмжилтийг хийж, лабораторийн боловсруулалтыг хийсэн.

Агаар орчны хяналт шинжилгээний дүнг тайлангийн орчны хяналт шинжилгээний хэсэгт нэгтгэн орууллаа.

5.1.2. Газрын доорх усны сөрөг нөлөөллийг бууруулах ажлын биелэлт

Хөрс, газрын доорх усанд бохирдол үүсгэхгүй байхаар асгаралт үүсэх тохиолдолд ашиглагдах асгаралтын багцыг засварын хэсэгт байршуулан ашиглалтын талаарх сургалт мэдээллийг ажилчдад өгсөн.




Зураг 2. Асгаралтын багц



Зураг 3. Ажилчдыг сургалт мэдээллээр хангасан байдал

2025 оны ус ашиглах дүгнэлтийг Хэнтий аймгийн Байгаль орчны газраас гаргуулан ус ашигласны төлбөрийг дүгнэлтэд тооцоолсон дүнгээр төлсөн.

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ГОЛОМТ БАНК <i>Сайн сайхны санхүүжилэл</i>		Цахим гүйлгээний баримт	
Хүсэлтийн лавлах дугаар: 371505201		Татсан огноо: 2025-10-16 10:54	
Шилжүүлэгчийн дансны дугаар 1905010491 MN350015001905010491	Хүлээн авагчийн данс 1165117377	Гүйлгээний дүн 319,105.00 MNT	Гүйлгээний төлөв Амжилттай
Шилжүүлэгчийн нэр РЕСУРСПАРТНЕРС ГРУПП	Хүлээн авагчийн нэр TAX	Гүйлгээний утга 3250801193838;32101434186;5556554;32101434186;99082810	
	Хүлээн авагчийн банк	Гүйлгээний огноо 2025-10-16	
Гүйлгээг шивсэн хэрэглэгч Д. ДОРЖДАЛАЙ	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч 	

Зураг 4. Унд ахуйд ус ашигласны төлбөр төлсөн баримт

5.1.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын биелэлт

Уурхайн олборлолтонд өртөх газрын шимт хөрсийг 20-30 см-ын зузаан хөрс хуулалт хийж 0,6 га талбайд 11,408м³ эзэлхүүнтэй шимт хөрсний овоолгыг уурхайн гадаад овоолго шорооны зүүн урд талд салхины нөөлөг газарт стандартын дагуу үүсгэсэн.



Зураг 5. Шимт хөрсний овоолгын байршил



Зураг 6. Шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлсэн байдал

5.1.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах ажлын биелэлт

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах, кемп орчимд доройтолд өртсөн газарт талхагдлыг бууруулахаар намрын мод тарилтын ажлыг зохион байгуулсан ба үүнд голт бор 20ш, хайлаас 20ш, нарс 10ш, монос 10ш, улиас 20 ш, шинэс 20ш тус тус тарилт хийсэн.



Зураг 7. Уурхайн кемп орчимд хийгдсэн мод тарилтын ажил



Ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажил болох нутгийн унаган ургамлын үрийг түүх хадгалах аргам хэмжээг авч хэрэгжүүлсэн.

5.1.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын биелэлт

Уурхайн талбайд жонш ангилан ялгах зориулалттай бутлуурын үйлдвэр ажиллуулахаар суурилуулалтын ажил хийгдэж байгаа ба цахилгаан дамжуулах агаарын шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил хийгдэж дууссан. Энэхүү цахилгаан дамжуулах шугам дээр шувуу цахилгаан цохихоос хамгаалан шувуу үргээгч суурилуулсан ба мөн уурхайн ойр орчимд шувууны суултыг байршуулсан.



Зураг 8. Уурхайн талбайн орчимд шувууны суулт байршуулсан байдал



Зураг 9. ЦДАШ-д шувуу үргээгч суурилуулсан байдал

5.2. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Гүйцэтгэл
1	Тэрбум мод тарих	Орон нутгаас төлөвлөсөн 1 га бүхий газар тарих	ширхэг	100	Сумын төвд мод тарих ажил хийгдсэн
2	Биологийн нөхөн сэргээлт-шимт хөрс болон биологи	Шимт хөрсний овоолго хийх	га	-	Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хийсэн

Тэрбум мод тарих хөтөлбөрийн хүрээнд Батноров сумын төвд (сумын хийдийн хажуу хашаанд) 1 га талбайд шинэс 8 ширхэг, агч мод 100 ш тарилт хийж усалгааны ажлыг эхлүүлсэн.



Зураг 10. Сумын төвд мод тарилтын ажил



Зураг 11. Сумын төвд мод тарилтын ажил

Уурхайн ажил эхлэх үед уурхайн хаалт нөхөн сэргээлтэнд зориулан шимт хөрсийг хуулан 20-30 см-ын зузаан хөрс хуулалт хийж 0,6 га талбайд 11,408м³ эзэлхүүнтэй шимт хөрсний овоолго үүсгэж хадгалсан.



Зураг 12. Шимт хөрсний овоолго (2025.07 сар)

5.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

	Дүйцүүлэн хамгаалах ажлын зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Гүйцэтгэл
1	Нөхөн сэргээлт аяны хүрээнд орхигдсон эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	1 га бүхий талбайд нөхөн сэргээлт хийх	Орон нутгаас санал болгосон	1 га	Хийгдсэн

Батноров сумын тамгын газраас эзэнгүй орхигдсон нөхөн сэргээлт хийх талбай байгаа эсэх талаар хүсэлт гарган харилцан санал солилцсоны үндсэн дээр сумын төвийн хогийн цэгт хогийг түрж булах, суманд орхигдсон барилгын хог хаягдлыг хогийн цэг рүү зөөвөрлөх ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 13. Хогийн цэг дээр түрэлт хийж байгаа үеийн зураг



Зураг 14. Хогийн цэгт түрэлт хийсний дараах үеийн зураг



Зураг 15. Барилгын хог хаягдлыг хогийн цэг рүү тээвэрлэх үеийн зураг

5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2025 оны БОМТ-ний хүрээнд нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох ажил хийгдээгүй.

5.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

5.6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Гүйцэтгэл
1	Ажилчдын биеийн эрүүл мэндийн байдалд нөлөөлөх, түүнийг хянах, урьдчилан сэргийлэх	Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилчид	Хийгдсэн
2	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр уурхайн кемпийг бүрэн хангах арга хэмжээ авах	Ажилчид	Хийгдсэн

Уурхайн нийт ажилчдыг 2025 оны 2-р сард Интермед эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.



Зураг 16. Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан



Зураг 17. Кемпд гал унтраах бэлэн байдлыг хангасан байдал

5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд ахуйн энгийн хог хаягдлыг түр хадгалах цэгийг хатуу хучилттай хийх, ангилан ялгах зориулалттай хогийн сав байршуулан ангилан ялгалт хийж уурхайн кемпэд түр хадгалахаар төлөвлөсөн. Аюултай хог хаягдлыг хүрээнд аюултай хог хаягдал хаях цэгийг сайжруулан хөрс, усан орчинд бохирдол үүсгэхгүйгээр эх үүсвэр дээр нь түр хадгалан аюултай хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх дахин боловсруулах зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагад шилжүүлэн ажиллах зорилт тавьсан.

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Гүйцэтгэл хийгдсэн
1	Ахуйн	Хог хаягдлыг хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж хаях, түр хадгалах хог хаягдлын цэгийн газрын гадаргууг цементлэх	Түр хадгалах хатуу ахуйн хатуу хог хаягдлын цэг	Хийгдсэн
2	Аюултай	Аюултай хог хаягдал болох ашигласан тос маслыг өөрийн талбайн түр хадгалах цэгт цуглуулах, тусгай зөвшөөрөл бүхий ААН-ээр гэрээ хийж устгуулах	Түр хадгалах аюултай хог хаягдлын цэг	Хийгдсэн

Уурхайн кемпэд ахуйн хог хаягдлын ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байршуулан ангилан ялгалт хийж түр хадгалсан.



Зураг 18. Ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Ахуйн хог хаягдал зайлуулах гэрээг Батноров сумын засаг даргатай хийсэн гэрээний дагуу сумын төвийн хогийн цэг рүү 2025 онд 1 удаа зөөвөрлөсөн.

БАТЛАВ: Хууль ёслолын дагуу Батноров сумын засаг дарга **С. АБОРЦУУЛАН**

БАТЛАВ: “РЕСУРС ПАРТНЕРС ГРУПП” ХХК-ын захирал **Д.ДАЯНДЭМЭД**

АХУЙН ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, БУЛАХ, УСТГАХ ГЭРЭЭ

№ 05

2025 он Батноров сум

Нэг талаас хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж “РЕСУРС ПАРТНЕРС ГРУПП” ХХК-ын захирал Д.ДАЯНДЭМЭД

Нөгөө талаас ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ сумын Засаг даргын Тамгын газрын дарга бид харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг: Гэрээний ерөнхий нөхцөл:

- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах, устгах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, санхүүжүүлэх журмын хоёр тал мөрдөж ажиллана.
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булах ажлыг стандарт шаардлагын дагуу чанартай гүйцэтгэх, сумын төв болон түүний орчинг цэвэр байлгахад хоёр талын үүрэг чиглэнэ.
- Энэхүү гэрээг 2025 оны 12 сарын 31-нээс эхлэн 2025 оны 12 сарын 31 хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.
- Гэрээний хугацаа дуусмагц гэрээг дүгнэж шинэчлэн байгуулж ажиллана.

Хоёр: Сумын Засаг дарга болон тамгын газрын хүлээх үүрэг

- Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд сумын төвийн хог хаягдлын төвлөрөн цэг болон хог хаягдал хадгалах түр цэгийн байршлыг тогтоох.
- Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх.
- Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, булах, устгах ажлыг орон нутгаас зохион байгуулах буюу хуулийн дагуу төсөвт хөрөнгө тусган зарцуулах.
- Иргэд, аж ахуйн нэгжийн болон багуудын нутаг дэвсгэрт байгаа хог хаягдлыг цэвэрлүүлэх хог хаягдлын төлбөрийн барагдуулалтанд хяналт тавьж түүнийг бүрэн барагдуулахад багийн Засаг дарга, чиглэлийн хяналтын улсын байцаагч нарын ажлыг чиглүүлж хариуцлага тооцуулах.
- Ахуйн хэрэглээгээс үүссэн буюу бусад аюултай хог хаягдлыг булах, устгах аргачлалыг баталж өгөх.
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах үйл ажиллагаанд идэвх, зүтгэл гарган оролцогчдоо эдийн засгийн урамшуулал олгох.

7. Сумын нутаг дэвсгэрт байгаа хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх ажилд иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах.

8. Хог хаягдал гаргагч иргэн, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас хог хаягдлын төлбөрийг тухай бүр нь гаргуулж хог хаягдлын үйлчилгээний санг бүрдүүлнэ.

Гурав: Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах, үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг

- Хог хаягдлыг зохих журмын дагуу цуглуулж тээвэрлэн хог хаягдлын цэгт хүргэх ба хог хаягдлын талбайг багаасгах, нөхөн сэргээх ажил үйлчилгээ явуулах.
- Хог хаягдлыг тээвэрлэх шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэх.
- Хог хаягдал булах устгах ажлыг Засаг даргын баталж өгсөн аргачлалын дагуу эрх бүхий мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл дүгнэлт гаргуулж гүйцэтгэнэ.
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булах, устгах ажлыг тодорхой баталсан төлөвлөгөө графикийн дагуу байнга хийнэ.
- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах болон бусад үйл ажиллагаа үзүүлсний баримт тодорхойлолтыг багийн ЗД, байцаагч, хогийн цэгийн сахиул нараар бүрдүүлнэ.
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжыг сумаас баталсан журмын дагуу сар бүр төлж явна.

Дөрөв: Хариуцлага

- Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргүүдийн биелэлтийг хоёр талаас комисс томилон жилийн эцэст дүгнэж байна.
- Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах, иргэн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, санхүүжүүлэх журмын 1.2-т заасан эрхийг нь цуцалж ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
- Үүргээ биелүүлээгүй сумын Засаг даргыг гэрээ дүгнэсэн комисс дүгнэлт гарган сумын ИТХ болон дээд шатны Засаг даргад танилцуулж ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлага тооцуулна.

Тав: Гэрээ байгуулсан

Хэнтий аймгийн БАТНОРОВ сумын ЗДТ-ын дарга **С. АБОРЦУУЛАН**

“РЕСУРС ПАРТНЕРС ГРУПП” ХХК-ын захирал **Д.ДАЯНДЭМЭД**

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА
ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР 2251003416804

ТАТВАРЫН АЛБА:
Татварын алба: Хэнтий
Татварын дэд алба: Батноров
Татварын төрөл: 01030723-Хог хаягдлын үйлчилгээний хураамж
Тайлант хугацаа: 2025-1
Төлөх дүн: 1200000

ТАТВАР ТӨЛӨГЧ:
Регистр /ТТД: 5556554
Татвар төлөгчийн нэр: Ресурспартнерс групп
Баримт үүсгэсэн огноо: 2025-10-16
Төлөх огноо: 2025-10-16

Зураг 20. Ахуйн хог хаягдлын төлбөр төлсөн баримт

Аюултай хог хаягдал түр хадгалах цэгийг хөрсөнд бохирдол үүсэхээс сэргийлэн цементлэн тохижуулсан. Шатах тослох материалын хаягдал, арчих материал, сэлбэгийн хог хаягдал, ашигласан тос масло зэргийг засварын хэсэг дэх аюултай хог хаягдлын хэсэгт ангилан ялгаж түр хадгалан Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт байрлах Алтан-Оршихуй Групп ХХК-ний аюултай хог хаягдал хадгалах, боловсруулах үйлдвэрт гэрээний дагуу хүргүүлдэг.



Зураг 21. Аюултай хог хаягдлын цэгийг дахин тохижуулсан байдал

2025 онд гэрээт байгууллага руу хаягдал дугуй нийт 11 ш, ашигласан тос масло 200 литр, тос маслоны хуванцар сав 30 ширхэг тус бүр шилжүүлсэн. Аюултай хог хаягдлын дагалдах гэрээ, дагалдах бичгийг доор хавсаргалаа.

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



БАТБАЯР
“РЕСУРС ПАРТНЕРС ГРУПП” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ДАЯНДЭМЭД



**“АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АДЬЯАСҮРЭН**

**ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС, ТОСОЛГООНЫ ШИНЭЭНИЙ ХАЯГДАЛЫГ
ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ГЭРЭЭ**

М/НЕС-Т-25-.....

2025 оны 10-р сарын 13-ны өдөр Улаанбаатар хот

Энэхүү Техникийн хаягдал тос, тосолгооны шинэ хаягдалыг хүлээлгэн өгөх гэрээ /шашид “Гэрээ” гэрээт нэг талаас Хэнтий аймгад Батноров сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг MV-021578 төст ашиглалтын тусгай зөвшөөрлийг Хэнтий-III талбайд үйл ажиллагаа явуулдаг “Ресурс партнерс групп” ХХК /шашид “Үүсгэгч” гэрээт төлөмж гүйцэтгэх захирал Д.Даяндэмэд нөгөө талаас Улаанбаатар хот, Багахангай дүүрэг 1 хороо хилийн гудамжинд байрлах **5537266** регистрийн дугаартай “Алтан Оршихуй Групп” ХХК /шашид “Боловруулагч” гэрээт төлөмж Гүйцэтгэх захирал Б.Адьяасүрэн нар /амтанд нь “Талууд” гэрээ Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, байгаль орчны нөхцөлөөр байдалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн үндэстэн дарах нөхцөлтэйгээр харилцан тохиролцоож энэхүү гэрээ байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Үүсгэгч нь өөрийн үйлдвэр, уурхайгаас гарах техникийн ашигласан хаягдал тос /шашид “Хаягдал тос” гэрээний холбогдох дүрэм, журмын дагуу цуглуулах, хадгалах, Үүсгэгчээс Боловруулагчид шилжүүлэх, Боловруулагч нь тээвэрлэх, хүлээн авах, устгахтай холбогсон үүсэх хариуцаж зохицуулахад оршино.
- 1.2. Хаягдал тос нь хог хаягдлын ангиллын төрлөөр аюултай хог хаягдлын А эрэгцээд *ИОАЖС/аюулт А-349 төсөн хөндөгсөн жижигхэн/аюулт* багтсан байгаль орчинд хор аюулын чанартай шингэн хог хаягдал юм.
- 1.3. Талууд гэрээгээр хүлээн үүргээ биелүүлэхэд байгаль орчны бохирдол гаргалгүй, галын аюулгүй байдлыг бүрэн сахих, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд үйл ажиллагаа явуулах шаардлагатай.
- 1.4. Энэхүү гэрээнд талууд нөгөө талаараа хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн гэрээгээр хүлээн үүргээ бүрэн биелүүлж үйл ажиллагаандаа хуулийн дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, үршгүй чанд хадгалах зарчмыг баримтална.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Гэрээ нь 2025 оны 10-р сарын 13 -ны өдөрөөс 2026 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хүчинтэй байна.
- 2.2. Гэрээний хугацааны хэрэгжилтийг хоёр тал харилцан үйл ажиллагаа зохиистой явагдсаны хувийн, дүрэм журмын биелэлтийг дүнжиж, сунгах санамж шийдвэрлэнэ.
- 2.3. Гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан, дүнжилтэнд дарах үйлсийн биелэлтийг дүгнэнэ.
- 2.4. Талууд гэрээг цуцлах саналаа ажлын 10 хоногос доошгүй хугацаанд нөгөө талдаа бичгээр мэдэгдэх бөгөөд шийдвэрийг хамтран гаргана.
- 2.5. Аль нэг талаас гэрээгээр хүлээн үүргээ ноцтой зорцсон буюу удаа дараа гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг нэг талын санаачлаар цуцалж болно.

ГУРАВ. ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Үүсгэгчийн хүлээлгэн өгөх хаягдал тосны үнэ нь 1 литр тутанд “0” төгрөг /төл төсрөөс/ байна.
- 3.2. Хоёр талд Аюултай хог хаягдлын жагсаалтын 13-р бүлэгийн хаягдалыг үнээх ёс туйн ашиг сонирхол байхгүй байна.
- 3.3. Энэхүү гэрээний хугацаанд хэзээ удаа тээвэрлэлт хийхийг талууд тухай бүр харилцан тохиролцоож шийдвэрлэнэ.
- 3.4. Үүсгэгч талын цуглуулсан хаягдал тосыг боловруулагч Багахангай дүүрэгт байрлах үйлдвэрт тээвэрлэж ирнэ.
- 3.5. Боловруулагч нь устгах, хоргуйжүүлэх зардалыг үл мөргөх журмаар 100% хариуцна.

ДӨРӨВ. ХАЯГДАЛ ТОС АЧИХ, ТЭЭВЭРЛЭХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ, ХҮЛЭЭН АВАХ

- 4.1. Хоёр тал эрх бүхий байгууллагаас баталсан аюултай хог хаягдалыг ангилах, цуглуулах, савлах, тэр байршуулах, тээвэрлэх аюулгүй болгох, хадгалах устгах журмыг дагаж мөрдөх.
- 4.2. Үүсгэгч нь өөрийн төслийн талбайгаас хаягдал тосыг цуглуулах, хадгалах, ачиж, хүлээлгэн өгөх, аюулгүй ажиллагааг бүрэн хариуцна.
- 4.3. Талууд энэ гэрээний дагуу хаягдал тос хүлээн авах, хүлээлгэн өгөхдөө санамж бичүүмжллийг шалгаж, акт үйлдэн хүлээн авна. Актанд талуудын тоолоогчид гарын үсэг зурж 2 хувь үйлдэнэ.
- 4.4. Талууд энэ гэрээний 4.1-т заасны дагуу шалгаж акт үйлдсэнээр хаягдал тостой холбоотой бүх эрсдэл Боловруулагч талд шилжинэ. Боловруулагч нь нийцүү хүлээн авсанаас хойшхи үүсэх аливаа эрсдэлийг *Ойгоо боловруулж бүх үе шатанд* бүрэн хариуцна.
- 4.5. Боловруулагч нь хаягдал тосны тээвэрлэлтийг гуравдагч этгээдээр хариуцуулан гүйцэтгүүлэх тохиолдолд энэхүү гэрээний бүх зүйл завтаг нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

ТАВ. ҮҮСГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Үүсгэгч нь дараах үүрэгтэй:

- 5.1.1. Хаягдал тосыг хүлээлгэн өгөхдөө гэрээний 4 дүгээр зүйлд заасны дагуу акт үйлдэн баталгаажуулж, Боловруулагчийн тоолоогчоор гарын үсэг зургаж авнас.
- 5.1.2. Хаягдал тосны хуримтлалын сав нь шинэ аюултай хаягдал хадгалах бүтээгдэхүүний стандартад нийцсэн, битүүмж адаглаагүй гаварт хадгалах;
- 5.1.3. Үүсгэгч нь Боловруулагчид хаягдал тосны хуримтлагдсан тоо хэмжээг 5-7 хоногийн өмнө мэдэгдэж, тээвэрлэлт хийх хугацааг тогтооно;
- 5.1.4. Үүсгэгч нь Боловруулагчийг гэрээ байгуулахаас хойш өөр бусад этгээлд хаягдал тос нийлүүлэхгүй байх, эсхүл өөрөө устгахгүй байх үүрэгтэй;
- 5.1.5. Боловруулагчийн хэвийн үйл ажиллагаанд аль болох саад учруулахгүй байх нөхцөлийг сонгож ажиллах бөгөөд Боловруулагчийн төслийн талбай, тусгай бүтэц, хэргэлсэн гавар тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хэргэлсэн байдалтай нэвтрэх, эмх замбараагүй байдал үүсгэхийг ажилгууддаа хориглох, тийм байдал үүсэхээс сэргийлж ажиллах;
- 5.1.6. Үүсгэгч нь Хууль болон гэрээгээр хүлээн бусад үүргээ биелүүлэх.

5.2. Үүсгэгч нь дараах эрхтэй:

- 5.2.1. Гэрээгээр хүлээн үүргээ биелүүлэхийг шаардах;
- 5.2.2. Боловруулагч талд санал хүсэлтээ мэдэгдэж шийдвэрлүүлэх;
- 5.2.3. Хууль болон гэрээнд заасан бусад эрх.

ЗУРГАА. БОЛОВРУУЛАГЧИЙН ҮҮРЭГ, ЭРХ

6.1. Боловруулагч нь дараах үүрэгтэй:

- 6.1.1. Боловруулагч нь хаягдал тосыг хүлээн авсанаар дүн шинжилгээ хийж, боловруулах, устгах үйл ажиллагааг хариуцна.

Зураг 22. Аюултай хог хаягдал шилжүүлэн өгөх гэрээ

5.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт шинжилгээний хүрээнд агаар, хөрс, усан орчинд доорх төлөвлөгөөнд заасны дагуу хээрийн хэмжилт, дээжлэлт хийж итгэмжлэгдсэн лабораториар шинжилгээ хийлгэхээр төлөвлөн ажилласан. Шинжилгээний дүнг холбогдох стандарттай харьцуулан дүгнэлтүүдийг гаргалаа.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний ажлын төлөвлөгөө

	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (урьдчилсан мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт шаардлагууд
1	Агаарын чанар: Агаарын тоосжилтын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар. Дуу чимээ хянуулах	Төслийн талбайн авто зогсоол, Ухашны салхин доод талд	Тоосны хяналт Төслийн талбайд 2 цэгт 1 удаадаа Өдөрт 2 удаа Жил бүрийн 9 сард	1200.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
2	Усны хяналт шинжилгээ Унд ахуйн усны ерөнхий хими үзүүлэх	Худаг: Унд ахуйн усыг хангаж буй гүний худгаас	Жил бүрийн 9 сард	234,5	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3	Хөрсний төлөв байдал, бохирдол: Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO3, P2O5, K2O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайн хог хаягдлын цэг болон ариун цэврийн байгууламжийн цэгт хөрсний эрүүл ахуйн бактерийн холимог дээж авах ШТС болон автомашин зогсоол хөрсний агрохими болон хүнд металлын дээж	Төслийн үйл ажиллагаа дуусахаас өмнө 1 удаа, Жил бүрийн 9 сард	1000,0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга, MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
---	--	---	--	--------	---

Уурхайн талбайд 2025 оны 10-р сард агаар, хөрс усны хяналт шинжилгээний ажлыг Хэнтий аймгийн Ус, цаг уур орчны хяналт шинжилгээний лаборатори, байгаль орчны зөвлөх үйлчилгээний Ганганбайгаль ХХК-иар хийж гүйцэтгүүлэн итгэмжлэгдсэн лабораторид дээжнүүдийг шинжилгээнд хамруулан дүгнэлт гаргууллаа.

5.8.1. Агаарын чанарын хэмжилт, шинжилгээний аргачлал

Монгол Улсын агаарын чанарын Агаар мандал Сорьц авах ерөнхий шаардлага MNS 3384:82, Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS 17.2.5.11-88, Агаар дахь хүхрийн хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS 17.2.5.12-88 стандартын дагуу нэг агшны хөндлөн огтлолт судалгааны загвараар тухайн нөхцөл дэх уртраг, өргөргийн тодорхой солбилцолд тоосны хэмжилтийг нийт тоос /TSP/, нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/, том ширхэглэгт тоосонцор /PM10/ үзүүлэлтээр DUSTTRAK II Aerosol Monitor DRX багажаар, Хүхэрлэг хий болон Азотын давхар исэлийг SKC Pocket Pump TOUCH, MP- ΣNII Series багажуудаар 20 минут хэмжсэн. Дээжийг лабораторийн орчинд азотын давхар исэл /NO2/-ийг нэг удаагийн агууламжийг шингээгч гуурсанд 0.25 л/минын хурдтай 20 спектрофотометрийн аргаар, хүхэрлэг хий /SO2/-г нэг удаагийн агууламжийг шингээгч гуурсанд 0.5 л/мин-ын хурдтай 20 минутын турш соруулж

тетрахлормеркурат /ТХМ/ натрийн аргаар тодорхойлсон. Судалгааны үр дүнг агаарын чанарын стандарт (MNS 4585:2016)-тай харьцуулж дүгнэлт өгсөн.


Агаар орчны хяналт шинжилгээ



Зураг 23. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийж буй байдал (10-р сар)

Хүснэгт 9. Агаарын хяналт шинжилгээний цэгийн байршил

№	Цэгийн дугаар	Цэгийн байршил	Уртраг	Өргөрөг
1	Хэмжилт хийсэн цэг-1	Уурхайн овоолгын урд	111°27'48.62"E	48° 6'48.90"N
2	Хэмжилт хийсэн цэг-2	Уурхайн овоолго дотор	111°27'55.92"E	48° 7'7.00"N



Зураг 24. Агаарын хяналт шинжилгээ хийгдсэн цэгүүдийн байршил

5.8.2. Агаарын хэмжилт, судалгааны үр дүн

Төслийн талбайн агаар дахь бохирдуулагч бодисуудын нэг удаагийн буюу 20 минутын дундаж хэмжилтийн үр дүнгээс үзэхэд нийт тоос, хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламж нь “Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016” -д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдолгүй байна (Лабораторийн шинжилгээний үр дүнг хавсаргав).

Хүснэгт 10. Агаарын чанарын шинжилгээний дүн

№	Хэмжилт хийсэн цэгүүд	Хэмжилт хийсэн цэг-1	Хэмжилт хийсэн цэг-2	Хүлцэх агууламж MNS4585:2025
1	Хүхэрлэг хий (SO ₂) мг/м ³	0.018	0.009	0.450
2	Азотын давхар исэл (NO ₂) мг/м ³	0.011	0.002	0.200
3	Нийт тоос (TSP) мг/м ³	0.009	0.006	0.150

5.8.3. Хөрсний хяналт шинжилгээ

Хавтгай III хайлуур жоншны ордын уурхайн талбайн хөрсний хяналт шинжилгээний ажлын хүрээнд хээрийн судалгаа дээж цуглуулалтын ажлыг 2025 оны 10-р сарын 6-ны өдөр 2 цэгээс авсан. Дээжийг авахдаа 10 см-ийн гүнээс дээжлэлт хийж “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990 стандартын шаардлагуудыг баримталсан. Дээжүүдийг Улаанбаатар хотод Цаг уур, орчны хяналт шинжилгээний газрын лабораторид шинжлүүлэн үр дүнгүүдийг холбогдох стандартуудтай харьцуулан дүгнэлт боловсрууллаа.



Зураг 25. Хөрсний хэмжилт хийсэн цэгийн байршил

Хүснэгт 11. Хөрсний хяналт шинжилгээний дүн

№	Цэгийн дугаар	Цэгийн байршил	Уртраг	Өргөрөг
1	Хөрсний хэмжилт хийсэн цэг-1	ШТС-ын зүүн талд	111°27'48.62"E	48° 6'57.08"N
2	Хөрсний хэмжилт хийсэн цэг-2	Энгийн хог хаягдлын цэг орчимд	111°27'41.12"E	48° 7'04.41"N

Хөрсний зүсэлт-1



Энэ цэг нь шатахуун түгээгүүрийн зүүн талд байрлах бөгөөд хөрсний гадарга нь бага зэрэг талхадсан, хөрсний өнгөн хэсэг нягт, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдалгүй цэвэр байна.

Хөрсний зүсэлт-2



Энэ цэг нь хог хаягдал түр хадгалах цэгийн дэргэд байрлах бөгөөд хөрсний өнгөн хэсэг нь хүний хөлийн болон техникийн нөлөөгөөр бага зэрэг талхлагдсан, элс болон давсны хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдлын бохирдол бага байна.

5.8.3.1. Хөрсний агро-хими, физик шинж чанар

Хөрсний урвалын орчин (pH)

Энэхүү үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг. Хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад нэн тохиромжтой гэж үздэг. Судалгааны үр дүнгээс харахад pH-ийн утгын хэлбэлзэл 8.55 буюу хүчтэй шүлтлэг орчинтой байна.

Хөрсний ялзмагийн агууламж

Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Ялзмагийн бодис их байх тусам хөрсний өнгө гүн хар болдог. Ялзмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь хөрсний физик нөхцөлийг сайжруулдаг, чийгийн

багтаамжийг нэмэгдүүлдэг, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлдөг, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн идэвхийг сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмждэг, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад буффер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэдэг, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болдог, хөрсний агаар солилцоог сайжруулдаг зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үнэлдэг. Энэ бүс нутаг нь хээрийн бүсэд хамаарах учраас хүний нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсөн бүрхэвч дунджаар 1.0% ялзмагтай байдаг (суурь судалгаа). Судалгааны үр дүнгээс харахад ялзмагийн утгын хэлбэлзэл 7.23% буюу ялзмагийн агууламж өндөр байна. Хөрсний хэмжилт судалгааны цэг-1-т бага зэрэг механик бохирдол үүссэн байна.

Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали (P2O5, K2O)

Хөрсний фосфор, кали (P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Фосфор (P) нь ургамлын эрүүл өсөлтөд шаардлагатай олон тооны чиг үүрэг гүйцэтгэж, бүтцийн чадавх, ургацын чанар, үрийн гарц зэрэгт илүү хувь нэмэр оруулдаг. Фосфор нь мөн ургамлын үндэсний өсөлтийг дэмжиж, цэцэглэж ургахад чухал нөлөөтэй байдаг. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P2O5) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксицыг агууламжаар нь <2мг/100г бол бага хангамжтай, 2-4мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Кали (K) нь өсөлт хөгжил болон бусад олон процессуудад чухал хэрэгтэй байдаг. Кали нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K2O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K2O)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад P2O5-ын утгын хэлбэлзэл 6,99 мг/л -ийн буюу хөдөлгөөнт фосфорын агууламж их байна.

Хүснэгт 12. Хөрсний мониторингийн цэгүүд дэх химийн шинжилгээний үзүүлэлтүүд

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Үр дүн
MNS3310:1991	Орчин	-	8.07
MNS3310:1991	Чийг – %	-	8.26
MNS3310:1991	Ялзмаг	-	19.85
MNS3310:1991	Аммиак –NH ₄ мг/л	-	59.60
MNS3310:1991	Нитрат NO ₃ мг/л	-	11.36
MNS3310:1991	Сульфат – SO ₄ мг/л	-	42.67
MNS3310:1991	Фосфор (P ₂ O ₅)	-	14.88

5.8.3.2. Хөрсний хүнд металл

Хөрсний хүнд металл гэдэг нь нягт нь 5 г/см³–ээс илүү, атом масс нь 40-өөс илүү, хөрсөнд тогтвортой удаан хугацаагаар хадгалагддаг, амьд организмд аюултай хор нөлөө үзүүлдэг, уусах чанар багатай, удаан задардаг био-идэвхт, хортой, онцгой хортой элементүүд юм. Судалгаагаар хөрсний мониторингийн цэгүүдээс авсан өнгөн хөрс (0-10см)- ний дээжүүдэд Кадьми (Cd), Хром (Cr), Зэс (Cu), Хар тугалга (Pb), Стронций (Sr), Цайр (Zn), Мөнгөн ус (Hg) зэрэг элементүүдийг тодорхойлуулсан. Эдгээр хүнд металлуудын үр дүнг доор хүснэгтэд дэлгэрэнгүй орууллаа.

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хүснэгт 13. Хөрсний мониторинг цэгүүд дэх хүнд металлын агууламж (10-р сар)

Цэгийн дугаар	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронций (Sr)
	мг/кг						
Хөрсний зүсэлтийн дугаар-1	3.0	15	<0.005	<0.05	110	22	926
Хөрсний зүсэлтийн дугаар-2	<0.05	19	<0.005	13	109	33	419
MNS 5850:2019 /2019/	3	100	2	150	300	100	800



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн ергэн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2025/709-710
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: "Ресурспартнерс групп" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Б.Ганганбайгаль БОШЛ-ийн шинжээч
Сорьцын тоо, төрөл	: 2 хөрсний сорьц
Сорьц авсан огноо	: 2025.10.09
Сорьцын тодорхойлолт	: Хэнтий аймаг
Шинжилгээний аргын стандарт	: САЗ А01:2022
Шинжилсэн огноо	: 2025.10.13
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн	

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронци (Sr)
1	Д-1	3.0	15	<0.005	<0.5	110	22	926
2	Д-2	<0.05	19	<0.005	13	109	32	419
	MNS 5850:2019/ ЗДХ/	3	100	2	150	300	100	800

Шинжилгээ гүйцэтгэсэн: *Б.Даваасүрэн*

Хянаж баталгаажуулсан: *Б.Алтантуяа*



Ахлах шинжээч Б.Даваасүрэн
Ахлах шинжээч Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 26. Хөрсний хүнд металлын шинжилгээний хариу

Хөрсний хар тугалга (Pb)

Хар тугалга нь Монгол улсын стандартаар онцгой хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл, сульфид байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний дээж авсан цэгүүдэд Pb-ын утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд жигд бага агууламжтай буюу 17-19 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хөрсний зэс (Cu)

Зэс нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс харахад Cu-ийн утгын хэлбэлзэл бүх

цэгүүдэд бага агууламжтай буюу 22-32 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 100 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хөрсний стронций (Sr)

Стронций нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс харахад Sr-ийн утга хөрсний дээж авсан 1-р цэгт 926мг/кг буюу стандартын хүлцэх агууламжаас өндөр, хөрсний дээж авсан 2-р цэгт 419 мг/кг агууламжтай буюу стандартын хүлцэх агууламж 800 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хөрсний цайр (Zn)

Цайр нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн цайрын исэл (ZnO) байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс харахад Zn-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд 109-110 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 300 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хөрсний хром (Cr)

Хром нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн Хромын гуравч исэл (CrO₃) байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс харахад Cr-ийн утгын хэлбэлзэл 0-13 мг/кг хооронд байна. Мониторинг цэгүүд дэх хөрсний Хромын агууламж стандартын хүлцэх агууламж 150 мг/кг-аас хэтрээгүй хэвийн хэмжээнд байна.

5.8.4. Усан орчны хяналт шинжилгээ

5.8.4.1.

Хавтгай-III талбайн 2025 усан орчны мониторингийн хээрийн судалгааны ажлыг 2025 оны 10 дугаар сарын 13 -ны өдөр хийж гүйцэтгэсэн.

Хээрийн судалгааны үед усны дээж авах, тээвэрлэхдээ “Унд ахуйн хэрэгцээний, үйлдвэрийн ус хангамжийн зориулалттай ус. Химийн шинжилгээний дээж авах аргачлал” MNS 3934:1986, Гүний уснаас дээж авах зөвлөмж” MNS ISO 5667-11:2000 стандартын дагуу 1.5 л багтаамжтай цэвэр усны саванд авсан. Дээж авахдаа дээжний савыг дээж авч буй эх үүсвэрийн усаар 2 удаа зайлж, савыг дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн явцад сэгсрэгдэх, хүчил төрөгчтэй тухайн дээж харилцан үйлчлэлд орохыг хязгаарлана. Дээжийг харанхуй, сэрүүн нөхцөлд хүйтэн баригч саванд хадгалж тээвэрлэсэн болно.

5.8.4.2.

Газрын доорх усны мониторингийн ажлын боловсруулалтыг хийхдээ унд ахуйн хэрэглээний усны шинжилгээний үр дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарттай, газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010 стандарт дүнтэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгсөн. Дээжийг Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораторийн харьяа Хэнтий аймгийн Байгаль орчны шинжилгээний лабораторид шинжилүүлсэн. Шинжилгээний хариуны баталгаажсан хувилбарыг тайлан хавсарган орууллаа.

Хүснэгт 14. Усан орчны мониторингийн цэгийн ерөнхий мэдээлэл

№	Хяналт шинжилгээний цэгийн нэр	Хяналт шинжилгээний цэгийн мэдээлэл	Шинжилгээ хийсэн үзүүлэлт	Уртраг	Өргөрөг
1	Усны мониторингийн цэг-1	Уурхайн талбай дээрх унд ахуйн зориулалттай худаг	Ерөнхий хими, физик үзүүлэлт	111°28'0.08"E	48° 6'52.75"N



Зураг 27. Усны мониторингийн цэгийн байршил

5.8.4.3.

Унд ахуйн зориулалттай худагаас дээж авах үед гүний худгийн үйл ажиллагаа хэвийн усны өнгө тунгалаг, үнэргүй байсан. Химийн бүрэлдэхүүнээрээ холимог ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Хүснэгт 15. Усны ерөнхий химийн шинжилгээний дүн

Тодорхойлсон үзүүлэлт Шинжилгээний арга стандарт		Сорьц авсан цэг	MNS 0900:2018
		Уурхайн ундны ус	хүлцэх агууламж мг/л
Жинлэгдэх бодис /MNS6836:2020/	Ж/Б мг/л	7.6	
Перманганатын исэлдэх чанар /MNS 6833:2020/	Пич мг/л	4.27	
Кальцийн ион / MNS 1097:2023/	Ca ²⁺ мг/л	48.6	100.0
Магнийн ион /MNS 1097:2023/	Mg ²⁺ мг/л	3.28	30.0

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Аммоний ион /MNS 1097:2023/	NH ₄ ⁺ мг/л	0.06	1.5
Нийт төмөр /MNS 4430:2023/	Fe мг/л	0.09	0.3
Хлорийн ион /MNS 4424:2005/	Cl ⁻ мг/л	22.9	350
Сульфатын ион / MNS 6217:2011/	SO ₄ ²⁻ мг/л	6.7	500.0
Нитритийн ион / MNS 6779:2019/	NO ₂ мг/л	0.004	1.0
Нитратын ион /MNS 6834:2020/	NO ₃ мг/л	9.76	50.0
Фосфатын ион /MNS ISO 6878:2001/	PO ₄ ³⁻ мг/л	0.592	3.5
Фтор /MNS 6272:2011/	F ⁻ мг/л	0.79	0.7-1.5
Хатуулаг /MNS ISO 6059:2005/	Хатуулаг мг-экв/л	2.70	7.0
Натри Кали	Na + K мг/л	59.29	-
Цахилгаан дамжуулах чанар / MNS 7888:1999/	EC S/cm ³	511	1000
Гидрокарбонат /MNS ISO 6832:2020/	HCO ₃	261.1	-
Эрдэсжилт MNS 1097:2023	мг/л	401.9	-
Орчин MNS ISO 10523:2001	pH	8.23	6.5-8.5

5.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаал	Гүйцэтгэл
		2025 он				
		8 сар	9 сар	10 сар		
1	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулах	захиалга	Явцтай танилцах	хүлээлцэх	ХАБЭА	2025 оны 4-р сард БОМТ батлуулсан
2	Энгийн хог хаягдлын гэрээ сунгуулах	захиалга	Явцтай танилцах	хүлээлцэх	ХАБЭА	Энгийн хаягдлын гэрээг тайлангийн хавсралт хэсэгт орууллаа.
	Нийт					

5.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 17. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцсан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Гүйцэтгэл
1	2025 БОМТ төлөвлөгөөг танилцуулах	Цаасан, цахимаар	Тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны	2025.02 сард	ХАБЭА	БОМТ-г сумын багийн иргэдийн хуралд

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

			менежментийн төлөвлөгөө			танилцуулга хийсэн
2	2025 оны БОМТ-ний дагуу хэрэгжилтийг тайлагнах	Цаасан, цахимаар	Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг батлуулах	2025.11 сард	ХАБЭА	Тайланг хуулийн хугацаанд аймгийн Хэнтий аймгийн Байгаль орчны газарт цаасан хэлбэрээр хүргүүлсэн.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төслийн нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний дагуу 10-р сард Батноров сумын Эхэнбүрд багийн хуралд оролцон тухайн онд хийгдсэн ажлуудын талаар танилцуулга хийж холбогдох санал шүүмжийг хүлээн авсан.



Зураг 28. Багийн хуралд танилцуулга хийх үеийн зураг

5.11. 2025 онд орон нутагт хийгдсэн ажлууд

Батноров сумын сургуулийн ойн хүрээнд сумын төвд зам засварын ажлыг энэ оны 7-р сард хийгдсэн. Мөн уурхайн ойр орчмын айлуудын хүсэлтийн дагуу бууц түрэх ажлыг хийж гүйцэтгэсэн (хийгдсэн ажлын холбогдох зургуудыг доор хавсралтаар орууллаа).



Зураг 29. Сумын төвийн зам засварын ажил



Зураг 30. Сумын төвийн зам засварын ажил



Зураг 31. Сумын төвийн зам засварын ажил



Зураг 32. Айлын өвөлжөөний бууц түрсэн ажил (айл 1)



Зураг 33. Айлын өвөлжөөний бууц түрсэн ажил (айл 2)



Зураг 34. Айлын өвөлжөөний бууц түрсэн ажил (айл 3)

**2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд зарцуулан
мөнгөн дүн**

	Зардлын утга	Нийт зарцуулсан дүн /төг/
	Агаарын чанар	ОХШХ-т тусгагдсан
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд зарцуулсан дүн	Гүний ус (асгаралтын багц, ус ашигласны төлбөр)	1, 819,105
	Хөрсөн бүрхэвч (шимт хөрсний овоолго үүсгэх-ү/а-ны дотоод зардлаар, тэмдэгжүүлэлт)	1,000,000

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

	Ургамлан нөмрөг(кемп орчимд мод тарилт)	2,850,000
	Амьтны аймаг	500,000
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	Тэрбум мод – сумын төвд	15,000,000
Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээнд зарцуулсан дүн	Орон нутгаас тавьсан саналын дагуу хогийн цэг түрэх булах ажил хийгдсэн	Үйл ажиллагааны дотоод зардлаар хийж гүйцэтгэгдсэн
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөнд зарцуулсан дүн	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгохтой холбоотой зардал гараагүй	-
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээнд зарцуулсан дүн	-	-
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан дүн	Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хамруулах	18,600,000
	Кемпд гал унтраах бэлэн байдлыг хангах	8,500,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан дүн	Ахуйн хог хаягдлыг түр цуглуулах, хадгалах цэгийг тохижуулах	Үйл ажиллагааны дотоод зардлаар
	Ангилан ялгах зориулалттай хогийн сав байршуулсан	2,100,00
	Хог хаягдлын төлбөр	1,200,000
	Аюултай хог хаягдлыг түр хадгалах цэгийг тохижуулах	13,500,000
	Аюултай хог хаягдлыг гэрээт байгууллагад шилжүүлсэн ажлын зардал	3,500,000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Лабораторын шинжилгээний дүн	870,000
	Мэргэжлийн байгууллагаар хээрийн судалгаа дээж бэлтгэл	1,500,000
	Мэргэжлийн байгууллагын шинжилгээний хариунд дүгнэлт хийлгэсэн ажлын төлбөр	2,500,000
Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын дүн	-	Үйл ажиллагааны дотоод зардалд тусгагдсан
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн	Багийн хуралд танилцуулсан	Үйл ажиллагааны дотоод зардалд тусгагдсан

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

бүсийн оршин суугчдад тайлагнах ажлын төлөвлөгөө		
Нийт зардал		69,520,000

VI. ХАВСРАЛТ

Хавсралт 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000030957

2012.01.25
/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011328128
/ Улсын бүртгэлийн дугаар /

5556554
/ Регистрийн дугаар /

Ресурспартнерс групп Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр **01** **2012.01.12**
/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

749900 Уул уурхайн зөвлөгөө
/ код / / Үндсэн зорилж үйл ажиллагааны чиглэл /

731000 Геофизикийн судалгаа

615000 Уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа

_____ _____
/ хос / / Туслах зорилж үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй **5** **1,000.0**
/ хугацаа / / өдөр/хуудсийн тоо / / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Чингэлтэй, 3-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, 23/3 - 54 тоот, утас1.99018614, утас2: , факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хөтө /



Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн
этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Харилцах дансны бүртгэл

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүр, эсэн ажилтан тэмдэг
Голомт төв банк	Төгрөгийн	1905010491	М. Энхбат
Голомт төв банк	Валютын	1905010492	М. Энхбат

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
2	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 0 хасардаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 6 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2016.05.04	Ж.Нямдорж

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

Хавсралт 2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хуулбар



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар *MV-021578*

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

_____ *Хэнтий* _____ аймаг /хот/-ийн
_____ *Батноров* _____ сум /дүүрэг/-ын
_____ *Хавтгай-III* _____ нэртэй газарт орших
_____ *633.58* _____ гектар талбай бүхий уурхайн талбайд
хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг
зөвшөөрч улсын бүртгэлийн _____ *9011328128* _____ тоот гэрчилгээтэй
_____ *“Ресурс партнерс групп” ХХК* _____ -д
энэхүү тусгай зөвшөөрлийг _____ *2050.04.15* _____ дуустал
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.ОДОНЧИМЭГ

2020 оны 4 сарын 21 өдөр
Улаанбаатар хот

0000444



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
2 ДУГААР ХАВСРАЛТ**

MV-021578

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001-NM	<ul style="list-style-type: none"> Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2020.04.15 	633.58 Га	0 Га	1	111° 27' 1.88"	48° 5' 51"
				2	111° 26' 7.18"	48° 5' 51"
				3	111° 26' 7.18"	48° 6' 35.76"
				4	111° 25' 41.87"	48° 6' 36.04"
				5	111° 25' 41.87"	48° 7' 1.81"
				6	111° 27' 1.88"	48° 7' 1.81"
				7	111° 27' 1.88"	48° 7' 51.81"
				8	111° 28' 31.87"	48° 7' 51.81"
				9	111° 28' 31.87"	48° 6' 51.85"
				10	111° 27' 1.88"	48° 6' 51.85"

2020-04-21 Ш.Мандахжаргал



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 31 өдөр

Дугаар #133

Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн ХХ-17-08 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших XV-021194 тоот тусгай зөвшөөрөлтэй Хавтгай-III хайлуур жоншны ордод 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан дахь жоншны нөөцийг нийт боломжтой (С) зэрэглэлээр хүдрээр 293.58 мян.тн, эрдсээр 122.89 мян.тн-оор хүлээн авсугай.

2. Хүлээн авсан геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Н.Мөнхбилэг/-д зөвшөөрсүгэй.

3. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших XV-021194 тоот тусгай зөвшөөрөлтэй Хавтгай-III хайлуур жоншны ордод 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг бичвэр дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг "Ресурс партнерс групп" ХХК /Д.Сүхбазар/-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар ХХ-17-08

Улаанбаатар хот

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших
Хавтгай-III хайлуур жоншны ордод 2019 онд
гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн
тайланг хэлэлцсэн тухай

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших Хавтгай-III хайлуур жоншны ордод 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр Монгол Улсын мэргэшсэн геологич Д.Сүхбазар, У.Эхтайван, З.Ариунбат, Э.Баярцэнгэл нарын боловсруулсан тайлан болон уг тайлан, ордын нөөцийн тооцоонд Монгол Улсын мэргэшсэн геологич Б.Батбаярын хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна. Үүнд:

1. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Баян Уул” нэртэй XV-021194 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зарлагдсан СШ-28 тоот сонгон шалгаруулалтанд оролцож шалгарсан “Ресурс партнерс групп” ХХК-д 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр олгосон байдаг.

“Хавтгай-III” хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 440 км, Хэнтий аймгийн төв Чингис хаан хотоос зүүн хойш 110 км, Батноров сумын төвөөс хойш 18 км-г оршдог.

2. “Ресурс Партнерс Групп” ХХК нь дээрх талбайд 2019 онд өөрийн хөрөнгөөр хайгуулын ажил гүйцэтгэж, хайлуур жоншны нөөцийг боломжтой (С) зэрэглэлээр тогтоож, хайгуулын ажилд нийт 250 842 500.00 төгрөг зарцуулжээ.

3. Энэ дүүрэгт 1977-1979 оны Ю.Я.Кошелев нар эрэл, эрэл үнэлгээний ажил, 1981-1984 онд Б.В.Коцюржинский, В.В.Шабалина нар эрэл, үнэлгээний ажил гүйцэтгэсэн. Эдгээр ажлын үр дүнд геологи, гидрогеологи, геоморфологи, ашигт малтмал талаас нь үнэлэлт дүгнэлт өгсөн.

Дээрх эрэл, эрэл үнэлгээний ажлын үр дүнгээр Хавтгай-III хайлуур жоншны ордын нөөцийг Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн 1984 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн №151 протоколоор 29.7 мян.тн хүдэрт 14.6 мян.тн эрдэс гэж тооцсон бөгөөд уг нөөцийг Бэрхийн уулын үйлдвэр ил аргаар олборлосон байдаг.

4. “Ресурс партнерс групп” ХХК нь 2019 онд уг хайгуулын талбайд өөрийн хайгуулын багаар петрографийн сорьцлолт 6 ш, “Эм Жи Эл Ди” ХХК-ийн өрөмдлөгийн багаар баганат өрөмдлөгийн 19 ш цооног, нийт 1341.8 т.м баганат өрөмдлөгийн ажил, кернийн 50 ширхэг сорьцлолтын ажлыг гүйцэтгэж, лабораторийн шинжилгээний ажлыг “ХанЛаб” ХХК-ийн итгэмжлэгдсэн лаборатори, усны шинжилгээг ШУА-ын Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн лаборатори, петрографийн судалгааг Монгол Улсын зөвлөх

инженер, доктор, профессор Д.Бат-Өлзий, 40.0 га талбайд 1:2000-ны масштабтай байр зүйн зураглал, цооногийн холболтын ажлыг “Жи Ди Эс Эс” ХХК тус тус гүйцэтгэсэн байна.

Палеонтологийн судалгааг ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төв, Археологийн судалгааг ШУТИС, БУХС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын профессорын багаар тус тус гэрээгээр гүйцэтгүүлжээ.

4. Хавтгай III хайлуур жоншны орд нь баруун хойш 325° чиглэлтэй 3.9 м өргөн, 150-240 м урттай кварц-флюоритын 3 биетээс тогтох ба түрүү палеозойн Хэрлэн бүрдлийн (PZ_{1k}) дунд ширхэгт боржин дахь тетоник суларлын бүс дагасан кварц-флюоритын судлын төрлийн III бүлгийн орд болох нь тогтоогджээ. Хүдрийн 3-н биет ялгаж нөөцийг тооцсон байна.

Хүдрийн биет-1: Уг хүдрийн биет нь кварц-флюоритын судал хэлбэрээр өргөргийн дагуу 240 м урттай сунасан, 3.9 м дундаж зузаантай, судлын уналын өнцөг 69° , хайлуур жоншны дундаж агуулга 40.36 %, хүдэр нь ногооноос шаргал өнгөтэй байна. Хүдрийн биетийн хэмжээнд боломжтой С зэргээр 144.9 мянган тн хүдэрт 40.36%-ийн агуулгатай 58.5 мянган тн хайлуур жонш тооцогдсон.

Хүдрийн биет-2: Хүдрийн биет-2 нь мөн адил кварц-флюоритын судал бөгөөд хүдрийн биет-1-ээс зүүн тийш 22.0-77.0м зайд байрлана. Уг хүдрийн биет нь баруун хойш 322° азимутаар, 163м урттай сунаж тогтсон, 4.6м дундаж зузаантай, 36.74%-ийн агуулгатай бэхэн ягаан өнгийн, дунд том мөхлөгт хайлуур жонш агуулдаг. Хайлуур жонш нь агуулагч боржингийн хил зааг орчимд брекчи маягийн хүдэр агуулдаг. Хүдрийн биет-2 хэмжээнд хайгуулын ажлын үр дүнгээр боломжтой С зэргийн үлдэгдэл нөөцийг 70.6 мянган тн хүдэрт 36.74%-ийн агуулгатай 25.9 мянган тн хайлуур жонш гэж тооцоолсон.

Хүдрийн биет-3: Энэ биет нь хүдрийн биет-2-той паралель 13.0-16.0м зайтай оршино. Хүдрийн биет-3 нь БХ328⁰ азимутаар, баруун тийш 70° уналын өнцөгтэй, 150м урттай сунаж тогтоно. Хайлуур жоншны хувьд том кристаллаг, ногоон өнгөтэй жонш зонхилох ба хүдрийн биетийг дагасан нарийн судланцарууд таарна. Хүдрийн биет-3 хэмжээнд боломжтой С зэргийн нөөцийг 78.1 мянган тн хүдэрт 49.27%-ийн агуулгатай 38.5 мянган тн хайлуур жонштой гэж тооцжээ.

6. Ордын үнэ цэнтэй эрдсийн тоонд хайлуур жонш орох бөгөөд цахир-хайлуур жоншны хүдрийн биет дэх фторт кальцийн агуулга ордын хэмжээнд тогтоогдсон хүдрийн эрдсийн найрлагад хайлуур жонш агуулга дунджаар 41.86%, цахир 28.0%, карбонат 0.7% хүхэр, фосфор илрээгүй байдаг.

7. Зохиогчид Хавтгай III хайлуур жоншны ордын геологийн нөөцийг боломжтой (С) зэрэглэлээр 293,577.2 тн хүдэрт дунджаар CaF₂-41.86 %-ийн агуулгатай 122,891.2 тн эрдэстэй гэж тооцжээ.

Шинжээч ордын нөөцийг дахин тооцоолж, зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээж авахыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг зүйтэй гэж үзэв.

8. Зохиогчид нөөцийн тооцоонд дараах жишигийн үзүүлэлтийг авч хэрэглэсэн байна. Үүнд:


Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан хайлуур жоншны ордын геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Н.Мөнхбилэг)-д зөвшөөрөх,

Гурав. Энэхүү дүгнэлтийн 11-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Ресурс партнерс групп” ХХК (Д.Сүхбазар)-д анхааруулах,

Дөрөв. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч баримт, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг “Ресурс партнерс групп” ХХК (Д.Сүхбазар)-д даалгах,

Тав. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших Хавтгай III хайлуур жоншны ордод 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан боловсруулалт, бүх төрлийн дээжлэлтийн ажлыг геологич Д.Сүхбазар, У.Энхтайван, З.Ариунбат, Э.Баярцэнгэл нар, өрөмдлөгийн ажлыг “Эм Жи Эл Ди” ХХК, химийн шинжилгээг “Ханлаб” ХХК-ийн итгэмжлэгдсэн лаборатори, 1:2000-ны масштабтай топо-геодезийн зураглалын ажлыг “Жи Ди Эс Эс” ХХК, дээрх гүйцэтгэсэн ажлын үнэн бодит байдал, чанарыг хянаж гаргасан дүгнэлтийг мэргэшсэн геологич Б.Батбаяр, хайгуулын ажлын үнэн бодит байдлыг “Ресурс Партнерс Групп” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:
ЭБМЗ-ИЙН ДАРГА  Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
ДАРГА  А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Б.БАЯРСАЙХАН




УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2024 оны 06 дугаар сарын 05 Дугаар 7/29-17-05 Улаанбаатар хот

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-021578 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хавтгай III хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай

Ресурс партнерс групп ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн Цариг ресурс ХХК боловсруулсан Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших Хавтгай III хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлд Монгол улсын зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Х.Жаргалсайхан шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.
